

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/082/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л. Мандахнаран

Утас: 99389927 Цахим хаяг: MandakhnaranLaudit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сул, Хөвсгөл аймаг, 87120
Утас/факс 7036 3793, Цахим шуудан.khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/187
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д. ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 963,408.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас гүйцэтгэлээр 910,450.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үлдэгдэл 52,958.7 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь хяргалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргажгүй.

Аудитаар нийт 49,225.1 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчлийг илрүүлснээс 46,377.7 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1,347.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1,500.1 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж, нийцлийн аудиттай холбоотой 4 зөвлөмж хүргүүлэв.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 74.2 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

8712022421

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Ордэнэбулган сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 74.2 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ОРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	135,340,576.94	162,640,788.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,665,258.02	6,729,747.02
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,665,258.02	6,729,747.02
3121	Төгрөг	22,665,258.02	6,729,747.02
31211	Төрийн сангийн харилцах	22,665,258.02	6,729,747.02
33	АВЛАГА	32,318,431.00	72,458,667.41
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,745,927.00	0.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	10,072,504.00	52,958,667.41
335	Бусад авлага	19,500,000.00	19,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	19,500,000.00	19,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	80,356,887.92	83,452,374.42
351	Түүхий эд материал	17,769,777.65	16,088,827.16
35130	Эм боох материал	17,769,777.65	16,088,827.16
354	Хангамжийн материал	62,587,110.27	67,363,547.26
35410	Бичиг хэргийн материал	1,641,459.00	1,348,749.00
35420	Аж ахуйн материал	44,304,667.36	48,733,198.76
35430	Сэлбэг хэрэгсэл	1,018,000.00	1,390,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,147,500.00	900,000.00
35450	Барилгын засварын материал	2,080,000.00	1,937,000.00
35460	Хүнсний материал	1,924,333.90	2,846,292.49
35470	Бусад хангамжийн материал	8,471,150.01	10,208,307.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,482,733,906.22	2,472,741,714.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,482,733,906.22	2,472,741,714.27
392	Биет хөрөнгө	2,456,784,697.96	2,446,795,839.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,398,110,620.00	2,398,110,620.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-99,003,382.87	-173,293,051.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,250,000.00	133,050,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,240,166.87	-59,864,000.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141,644,720.00	189,689,780.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,881,717.66	-67,907,165.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,231,772.00	46,231,772.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,375,480.08	-31,657,116.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,650,000.00	17,650,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,601,666.56	-5,215,000.00
393	Биет бус хөрөнгө	25,949,208.26	25,945,874.93
39301	Програм хангамж	475,000.00	475,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-234,791.74	-238,125.07
39303	Бусад биет бус хөрөнгө	25,709,000.00	25,709,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,618,074,483.16	2,635,382,503.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,316,377.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,316,377.00	
413	Өглөг	7,316,377.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,570,450.00	
4136	Бусад өглөг	2,745,927.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,745,927.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,610,758,106.16	2,635,382,503.12
51	Засгийн газрын хувь оролцоо	2,610,758,106.16	2,635,382,503.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	195,317,795.00	195,317,795.00
51101	Өмч: - төрийн	195,317,795.00	195,317,795.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,284,835,905.16	2,309,460,302.12
51210	Өмнөх үеийн үр дүн	2,284,835,905.16	2,284,835,905.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	24,624,396.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,604,406.00	130,604,406.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,618,074,483.16	2,635,382,503.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,005,337,596.59	1,256,202,478.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,302,939,050.05	148,381,093.80
120	Нийтлэг татварын бус орлого	2,302,914,372.05	148,381,093.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,302,914,372.05	148,381,093.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,302,914,372.05	148,381,093.80
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	24,678.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	24,678.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	702,398,546.54	1,107,821,384.25
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	46,610,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	46,610,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,525,100.00	107,875,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,525,100.00	107,875,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	664,873,446.54	953,336,184.25
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	664,873,446.54	953,336,184.25
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	822,710,343.54	1,231,578,081.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	822,710,343.54	1,231,578,081.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,003,288.55	1,098,410,041.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,262,428.52	689,502,587.84
210101	Үндсэн цалин	328,662,409.52	420,520,426.00
210102	Нэмэгдэл	118,329,658.00	214,007,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,018,238.00	10,873,190.00
210104	Урамшуулал	64,252,123.00	44,101,971.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,439,890.00	86,672,700.00
210201	Тэтгэврийн даатгал	48,531,867.18	58,937,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,075,000.00	6,933,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,259,600.00	3,467,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	919,499.82	3,467,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,653,923.00	13,867,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,782,412.01	15,536,160.86
210301	Гэрэл, цахилгаан	8,823,445.01	9,136,160.86
210302	Түлш, халаалт	16,158,967.00	
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	6,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,759,329.00	42,393,822.00
210401	Бичиг хэрэг	3,248,527.00	2,393,190.00
210402	Тээвэр, шатахуун	24,772,888.00	26,800,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,196,000.00	2,348,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	255,800.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,286,114.00	10,852,062.00
2105	Нормативт зардал	97,212,526.48	98,780,722.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,385,926.00	84,090,236.55
210502	Хоол, хүнс	14,076,600.48	14,690,485.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,750,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,416,700.03	15,631,100.00
210602	Тавилга	6,820,000.03	
210604	Урсгал засвар	3,596,700.00	15,631,100.00
2107	Томилолт, зочны зардал	278,000.00	1,985,100.00
210702	Дотоод албан томилолт	278,000.00	1,985,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,267,328.00	10,789,844.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	447,100.00	8,808,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,393,500.00	1,497,044.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	150,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,000.00	74,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	49,500.00
210807	Газрын төлбөр	209,700.00	209,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	162,028.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,584,674.51	137,118,004.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,371,600.00	5,280,753.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,213,074.51	131,837,251.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,707,054.99	133,168,039.14
2132	Бусад урсгал шилжүүлэг		44,610,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		37,680,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,930,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,707,054.99	88,558,039.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,707,054.99	88,558,039.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,182,627,253.05	24,624,396.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,182,627,253.05	24,624,396.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	692,350,720.54	1,064,935,220.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,678.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	24,678.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	24,678.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	692,326,042.54	1,064,935,220.84
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		46,610,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		46,610,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,525,100.00	107,875,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,525,100.00	107,875,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	654,800,942.54	910,450,020.84
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	654,800,942.54	910,450,020.84
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	713,853,492.52	1,080,870,731.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	713,853,492.52	1,080,870,731.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	687,146,437.53	947,702,692.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,967,418.52	689,502,587.84
210101	Үндсэн цалин	328,367,399.52	420,520,426.00
210102	Нэмэгдэл	118,329,658.00	214,007,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,018,238.00	10,873,190.00
210104	Урамшуулал	64,252,123.00	44,101,971.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,734,900.00	86,672,700.00
210201	Тэтгэврийн даатгал	44,435,900.00	58,937,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,075,000.00	6,933,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,259,600.00	3,467,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	815,000.00	3,467,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,149,400.00	13,867,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,623,445.01	15,536,160.86
210301	Гэрэл, цахилгаан	8,823,445.01	9,136,160.86
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	6,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,980,662.00	35,475,639.00
210401	Бичиг хэрэг	439,300.00	470,000.00
210402	Тээвэр, шатахуун	25,559,178.00	24,553,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,196,000.00	1,996,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,846,336.00	3,325,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,939,848.00	5,130,819.00
2105	Нормативт зардал	50,070,824.00	82,056,368.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,899,060.00	66,877,059.00
210502	Хоол, хүнс	6,431,804.00	14,737,989.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,739,960.00	441,320.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,381,600.00	14,488,193.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,925,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,456,600.00	14,488,193.00
2107	Томилолт, зочны зардал	278,000.00	1,985,100.00
210702	Дотоод албан томилолт	278,000.00	1,985,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,083,988.00	12,355,124.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	375,300.00	8,338,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,465,300.00	1,497,044.00
210803	Даатгалын үйлчилгээ		150,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,000.00	74,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	49,500.00
210807	Газрын төлбөр	209,700.00	209,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	978,688.00	2,035,280.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,025,600.00	9,630,820.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,025,600.00	9,630,820.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,707,054.99	133,168,039.14
2132	Бусад урсгал шилжүүлэг		44,610,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		37,680,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,930,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,707,054.99	88,558,039.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,707,054.99	88,558,039.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-21,502,771.98	-15,935,511.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,075,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,075,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	3,075,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,075,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,075,000.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-24,577,771.98	-15,935,511.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		22,665,258.02
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,665,258.02	6,729,747.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	195,317,795.00	130,604,406.00	2,284,835,905.16	2,610,758,106.16
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,317,795.00	130,604,406.00	2,284,835,905.16	2,610,758,106.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	195,317,795.00	130,604,406.00	2,284,835,905.16	2,610,758,106.16
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,624,396.96	24,624,396.96
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,317,795.00	130,604,406.00	2,309,460,302.12	2,635,382,503.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,051,824,800.00	972,995,531.84	92.51	78,829,268.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,051,824,800.00	972,995,531.84	92.51	78,829,268.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	951,034,800.00	928,385,531.84	97.62	22,649,268.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	694,922,100.00	689,502,587.84	99.22	5,419,512.16
210101	Үндсэн цалин	421,857,800.00	394,097,621.22	93.42	27,760,178.78
210102	Нэмэгдэл	214,007,000.00	213,825,288.62	99.92	181,711.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,375,300.00	35,298,443.00	245.55	20,923,143.00
210104	Урамшуулал	44,682,000.00	46,281,235.00	103.58	-1,599,235.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,641,100.00	86,672,700.00	98.90	968,400.00
210201	Тэтгэврийн даатгал	59,887,000.00	58,937,000.00	98.41	950,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,938,400.00	6,933,800.00	99.93	4,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,469,300.00	3,467,000.00	99.93	2,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,469,300.00	3,467,000.00	99.93	2,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,877,100.00	13,867,900.00	99.93	9,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,141,500.00	35,475,639.00	86.23	5,665,861.00
210401	Бичиг хэрэг	1,308,700.00	470,000.00	35.91	838,700.00
210402	Тээвэр, шатахуун	27,508,000.00	24,553,070.00	89.26	2,954,930.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	1,996,000.00	66.18	1,020,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,308,700.00	2,690,950.00	62.45	1,617,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	5,765,619.00	115.31	-765,619.00
2105	Нормативт зардал	85,097,200.00	82,056,368.00	96.43	3,040,832.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,739,100.00	66,877,059.00	101.73	-1,137,959.00
210502	Хоол, хүнс	14,621,100.00	14,737,989.00	100.80	-116,889.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,737,000.00	441,320.00	9.32	4,295,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,837,000.00	10,707,193.00	77.38	3,129,807.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,503,900.00		0.00	1,503,900.00
210602	Тавилга	333,400.00		0.00	333,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	749,700.00		0.00	749,700.00
210604	Урсгал засвар	11,250,000.00	10,707,193.00	95.18	542,807.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	1,985,100.00	39.70	3,014,900.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	1,985,100.00	39.70	3,014,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,744,600.00	12,355,124.00	89.89	1,389,476.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,347,900.00	8,338,600.00	99.89	9,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,497,044.00	99.80	2,956.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,300.00	150,300.00	100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74,700.00	74,700.00	100.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,500.00	49,500.00	100.00	0.00
210807	Газрын төлбөр	209,700.00	209,700.00	100.00	0.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,412,500.00	2,035,280.00	59.64	1,377,220.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,651,300.00	9,630,820.00	99.79	20,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,651,300.00	9,630,820.00	99.79	20,480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,790,000.00	44,610,000.00	44.26	56,180,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,790,000.00	44,610,000.00	44.26	56,180,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	93,860,000.00	37,680,000.00	40.14	56,180,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,930,000.00	6,930,000.00	100.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,051,824,800.00	957,060,020.84	90.99	94,764,779.16
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	941,159,800.00	910,450,020.84	96.74	30,709,779.16
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	941,159,800.00	910,450,020.84	96.74	30,709,779.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,665,000.00	46,610,000.00	42.12	64,055,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	22,665,258.02		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	6,729,747.02		-6,729,747.02

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	107,875,200.00	19,317,160.86	17.91	88,558,039.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,875,200.00	19,317,160.86	17.91	88,558,039.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107,875,200.00	19,317,160.86	17.91	88,558,039.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,875,200.00	15,536,160.86	14.96	88,339,039.14
210301	Гэрэл, цахилгаан	9,374,400.00	9,136,160.86	97.46	238,239.14
210302	Түлш, халаалт	91,500,800.00		0.00	91,500,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	6,400,000.00	213.33	-3,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	3,781,000.00	94.53	219,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	3,781,000.00	94.53	219,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	107,875,200.00	107,875,200.00	100.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	107,875,200.00	107,875,200.00	100.00	0.00
320001	Орон нутгийн төсвөөс	107,875,200.00	107,875,200.00	100.00	0.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 49,225.2 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчлийг илрүүлснээс 46,377.7 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1,347.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1,500.1 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж, нийцлийн аудиттай холбоотой 4 зөрчилд тус тус зөвлөмж хүргүүлэв. мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

5.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой нийт 43,531.7.1 мянган төгрөгийн доорх гүйлгээг буруу бүртгэсэн алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын хугацаанд холбогдох дансанд бүртгэж залруулсан. Үүнд:

- Бараа материалын тодруулгад 4,814.3 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг биологийн хөрөнгө дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний журналд бүртгэж залруулсан.
- Бараа материалын тайланд 958.6 мянган төгрөгийн хүнсний материалыг хангамжийн материал дансанд 857.4 мянган төгрөг, аж ахуйн материал дансанд 101.2 мянган төгрөгөөр тус тус орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний журналд бүртгэж залруулсан.
- Мөнгөн гүйлгээний тайланд хүнсний материал худалдан авсан 958.5 мянган төгрөгийг хог хаягдлын зардлаар 323.8 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлсийн зардлаар 634.8 мянган төгрөгийг тус тус тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний журналд бүртгэж залруулсан.
- Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон арга хэмжээ /80302/-ний үндсэн цалингийн зардал 33,925.3 мянган төгрөгийг унаа болон хоолны зардалд, 2,975.2 төгрөгийн цалингийн урьдчилгааг урамшууллын зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний журналд бүртгэж залруулсан.
- Ерөнхий журналд өмнө оны авлага 2,745.9 мянган төгрөгийг өмнөх оны үр дүнг бууруулж алдаатай бичилт хийснээс тайлант үеийн үр дүнг буруу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул ерөнхий журналд залруулж бүртгэсэн.

5.2 Албан шаардлага

Тайлант онд вакцины сувлагч Н. Эрдэнэжаргалын мэргэжлийн зэргийн гэрчилгээний хугацаа дууссан байхад 1,347.3 мянган төгрөгийн нэмэгдэл олгосог нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчийн мэргэшлийн зэргийг 5 жил тутам шинэчлэн тогтооно” заалтад нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,847.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 12,299.3 мянган төгрөгөөс 10,316.2 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2.Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлсийн зардлаас машины татварт 144.9 мянган төгрөг, машины даатгалд 62.0 мянган төгрөг, бохирын насос засварын үнэ 314.6 мянган төгрөг, Санхүүгийн программын сунгалтын төлбөрийг бичиг хэргийн зардлаас 470.0 мянган төгрөг, томилолтын зардлаас тогоочийн сургалтын төлбөрт 106.1 мянган төгрөг, интернэтийн төлбөрт эм боох материалын зардлаас 176.0 мянган төгрөг, цалингийн зардлаас 176.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас бичиг хэргийн материалд 50.5 мянган төгрөг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" заавартай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж ажиллах

3. Мэргэшлийн зэргийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Вакцины сувилагч Н. Эрдэнэжаргалд хугацаа дууссан мэргэжлийн зэргийн гэрчилгээ үндэслэн мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон нь Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.5-д "сувилагчид сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар "Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 4-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчийн мэргэшлийн зэргийг 5 жил тутам шинэчлэн тогтооно" заалтад нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дээрх хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

4.Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 31, зарлагын 10 гүйлгээг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 25 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 заалт "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6.4.5 заалт "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8 заалт "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалт болон "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2024 онд 966,113.2 мянган төгрөгийг нэхэмжилснээс 12,776.9 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;" Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолын 3.1 "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,.." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах

2. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах..." гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

7.Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой асуудал.

Илрүүлэлт:

Бараа материалын дансанд тайлант жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 862.2 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эмийн захиалгыг тухайн эмийн хэрэглээ, үлдэгдэл, хэрэгцээнд үндэслэн оновчтой хийж байх, эмийн хадгалалтын хугацаанд байнга хяналт хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч байх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

1. Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл.

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тодруулгад 4,814.3 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг биологийн хөрөнгө дансанд бүртгэсэн	1	4,814.3			1	4,814.3	1	4,814.3		
Бараа материалын тайланд 958.6 мянган төгрөгийн хүнсний материалыг хангамжийн материал дансанд, 857.4 мянган төгрөг, аж ахуйн материал дансанд 101.2 мянган төгрөгөөр тус тус орлого авсан	1	958.5			1	958.5	1	958.5		
Мөнгөн гүйлгээний тайланд хүнсний материал худалдан авсан 958.5 мянган төгрөгийг хог хаягдлын зардалд 323.8 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлсийн зардалд 634.8 мянган төгрөгөөр тус тус тайлагнасан	1	958.5			1	958.5	1	958.5		
Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон арга хэмжээ /80302/-ний үндсэн	1	36,900.5			1	36,900.5	1	36,900.5		

цалингийн зардал 33,925.3 мянган төгрөгийг унаа болон хоолны зардалд 2,975.2 төгрөгийн цалингийн урьдчилгааг урамшууллын зардалд бүртгэсэн									
Ерөнхий журналд өмнө оны авлага 2,745.9 мянган төгрөгийг өмнөх оны үр дүнг бууруулж алдаатай бичилт хийснээс тайлант үеийн үр дүнг буруу илэрхийлсэн	1	2,745.9			1	2,745.9	1	2,745.9	
	5	46,377.7			5	46,377.7	5	46,377.7	

2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөг

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Вакцины сувилагч Н. Эрдэнэжаргалд хугацаа дууссан мэргэжлийн зэргийн гэрчилгээгээр мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон	1	1,347.3					1	1,347.3
Зардлын зориулалт, арга хэмжээнд нийцүүлж зарцуулаагүй байна	1	1,500.1					1	1,500.1
Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон	1	0					1	0
Дүн	3	2,847.4					3	2,847.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7 мэдээлэл оруулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	0,0					1	0,0
Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2024 онд 966,113.2 мянган төгрөгийг нэхэмжилснээс 12,776.9 мянган төгрөг хасагдсан	1	0,0					1	0,0
Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй	1	0,0					1	0,0
Тайлант жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 862.2 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг тууштай мөрдөөгүй байна.	1	0,0					1	0,0
Дүн	4	31,218.7					3	31,218.7



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 32/ААТ-0469/

Мөрөн сум

ХАА-2025/052/НА СГБ-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд вакцины сувиллагч Н.Эрдэнэжаргалын мэргэжлийн зэргийн гэрчилгээний хугацаа дууссан байхад 1,347,344 (нэг сая гурван зуун дөчин долоон мянга гурван зуун дөчин дөрөв) төгрөгийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хэвсрэлтээр -ын 4-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчийн мэргэшлийн зэргийг 5 жил тутам шинэчлэн тогтооно" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мадагдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлсээгүй бол алдаа, зөрчлийг төвлөн зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгнө, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд дотор оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д. Лхагвасүрэн, нягтлан бодогч Э. Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО



67240 0550